

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/26/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/50
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.БОЛОРМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ 19020222

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	159,662,131.50	161,898,823.27
33	АВЛАГА	00.00	63,403.77
335	Бусад авлага	00.00	63,403.77
3351	Байгууллагаас авах авлага	00.00	43,574.97
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	19,828.80
35	БАРАА МАТЕРИАЛ	159,662,131.50	161,835,419.50
351	Түүхий эд материал	162,500.00	162,500.00
35130	Эм боох материал	162,500.00	162,500.00
354	Хангамжийн материал	121,589,631.50	124,582,919.50
35410	Бичиг хэргийн материал	3,699,118.00	4,779,488.00
35420	Аж ахуйн материал	59,788,847.00	59,937,717.00
35430	Сэлбэг хэрэгсэл	775,361.50	267,939.50
35440	Түлш, шатах тослох материал	1,268,320.00	00.00
35450	Барилгын засварын материал	51,667,365.00	56,693,555.00
35460	Хүнсний материал	3,307,020.00	2,680,220.00
35470	Бусад хангамжийн материал	1,083,600.00	224,000.00
35600	Мал амьтад	37,910,000.00	37,090,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,298,935,819.43	2,162,507,432.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,298,935,819.43	2,162,507,432.17
392	Биет хөрөнгө	1,664,913,981.06	1,529,282,781.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,445,326,579.00	1,445,326,579.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,205,887.84	-122,022,079.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,168,083.30	133,168,083.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,120,209.38	-108,905,345.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,602,091.55	193,999,178.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,343,629.06	-126,434,065.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,989,599.36	171,716,717.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,407,407.87	-82,302,790.53
39217	Ном	21,904,762.00	24,736,504.00
393	Биет бус хөрөнгө	634,021,838.37	633,224,650.86
39301	Программ хангамж	16,525,000.00	16,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,789,270.91	-7,586,458.42
39303	Бусад биет бус хөрөнгө	624,286,109.28	624,286,109.28
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,458,597,950.93	2,324,406,255.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	63,403.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	63,403.77
413	Өглөг	00.00	63,403.77
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	43,574.97
4136	Бусад өглөг	00.00	19,828.80
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	19,828.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,458,597,950.93	2,324,342,851.67

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	2,458,597,950.93	2,324,342,851.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,198,901,961.28	1,198,901,961.28
51101	Өмч: - төрийн	1,198,901,961.28	1,198,901,961.28
512	Хуримтлагдсан үр дүн	-244,978,937.15	-379,234,036.41
51210	Өмнөх үеийн үр дүн	-244,978,937.15	-244,978,937.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-134,255,099.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,504,674,926.80	1,504,674,926.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,458,597,950.93</u>	<u>2,324,406,255.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,065,542,186.80	1,082,750,107.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,982,569.80	39,130,221.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,690,749.00	39,130,221.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,690,749.00	39,130,221.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,495,949.00	8,850,396.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,444,800.00	5,473,788.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,750,000.00	24,806,037.00
122	Тусламжийн орлого	23,291,820.80	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	23,291,820.80	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,009,559,617.00	1,043,619,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,003,137,300.00	1,040,469,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,003,137,300.00	1,040,469,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,422,317.00	3,150,686.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,200,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,222,317.00	3,150,686.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,058,367,082.29	1,231,762,206.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,058,367,082.29	1,231,762,206.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	917,504,754.65	1,155,073,767.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,372,551.00	602,042,973.60
210101	Үндсэн цалин	539,372,551.00	374,063,419.00
210102	Нэмэгдэл	00.00	167,097,120.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	25,813,225.00
210104	Урамшуулал	00.00	35,069,209.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,857,645.56	80,703,542.90
210201	Тэтгэврийн даатгал	47,546,516.56	56,777,440.05
210202	Тэтгэмжийн даатгал	5,708,603.00	6,243,029.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,314,419.00	4,863,383.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,191.00	1,155,885.56
210205	Эрүүл мэндийн даатгал	10,261,916.00	11,663,803.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,564,361.00	191,350,009.75
210301	Гэрэл, цахилгаан	20,586,605.00	20,730,649.75
210302	Түлш, халаалт	135,352,756.00	164,271,360.00
210303	Цэвэр, бохир ус	7,625,000.00	6,348,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,322,019.00	36,726,209.00
210401	Бичиг хэрэг	3,102,670.00	2,426,430.00
210402	Тээвэр, шатахуун	5,131,180.00	7,288,523.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,916,424.00	4,592,085.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,344,200.00	4,516,190.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,827,545.00	17,902,981.00
2105	Нормативт зардал	16,485,270.00	14,419,818.00

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	743,500.00
210502	Хоол, хүнс	16,185,270.00	12,651,018.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,025,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,192,390.00	32,328,888.00
210604	Урсгал засвар	14,192,390.00	32,328,888.00
2107	Томилолт, зочны зардал	1,005,000.00	404,000.00
210702	Дотоод албан томилолт	1,005,000.00	404,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,252,199.80	4,044,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,504,200.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,577,899.80	428,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,800.00	255,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	174,500.00	182,960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,564,800.00	739,360.00
210807	Газрын төлбөр	200,000.00	19,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,453,318.29	193,053,446.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,577,200.00	22,894,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,804,086.00	21,528,922.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,072,032.29	148,630,524.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,862,327.64	76,688,438.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,812,900.00	56,873,190.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	70,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	110,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,670,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,459,900.00	32,222,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,173,000.00	980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	113,049,427.64	19,815,248.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,049,427.64	19,815,248.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,175,104.51	-149,012,099.26
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	25,956,200.00	14,757,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	25,956,200.00	14,757,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	25,956,200.00	14,757,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,131,304.51	-134,255,099.26

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	-272,562,563.97	00.00	737,526,715.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	-272,562,563.97	00.00	737,526,715.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	624,286,109.28	00.00	-27,912,543.01	00.00	596,373,566.27
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-244,978,937.15	00.00	2,458,597,950.93
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-244,978,937.15	00.00	2,458,597,950.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-244,978,937.15	00.00	2,458,597,950.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-134,255,099.26	00.00	-134,255,099.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-379,234,036.41	00.00	2,324,342,851.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,018,150,566.00	1,052,620,282.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,590,949.00	9,000,396.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,590,949.00	9,000,396.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,590,949.00	9,000,396.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,590,949.00	9,000,396.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,009,559,617.00	1,043,619,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,003,137,300.00	1,040,469,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,003,137,300.00	1,040,469,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,422,317.00	3,150,686.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,200,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,222,317.00	3,150,686.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,018,150,566.00	1,052,620,282.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,018,150,566.00	1,052,620,282.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,288,238.36	975,931,843.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,392,548.64	602,042,973.60
210101	Үндсэн цалин	332,723,554.57	374,063,419.00
210102	Нэмэгдэл	155,193,273.07	167,097,120.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,472,325.00	25,813,225.00
210104	Урамшуулал	29,003,396.00	35,069,209.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,857,647.72	80,703,543.90
210201	Тэтгэврийн даатгал	52,470,800.96	56,652,362.60
210202	Тэтгэмжийн даатгал	4,940,775.98	6,202,463.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,673,796.78	4,854,510.93
210204	Ажилгүйдлийн даатгал	273,347.75	1,171,980.40
210205	Эрүүл мэндийн даатгал	7,498,926.25	11,822,226.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,564,361.00	191,350,009.75
210301	Гэрэл, цахилгаан	18,807,739.00	20,730,649.75
210302	Түлш, халаалт	137,131,622.00	164,271,360.00
210303	Цэвэр, бохир ус	7,625,000.00	6,348,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,957,880.00	21,399,120.00
210401	Бичиг хэрэг	2,899,580.00	2,583,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,893,000.00	6,202,053.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,668,300.00	4,592,085.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,613,100.00	2,816,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,883,900.00	5,205,482.00
2105	Нормативт зардал	20,854,710.00	16,103,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	923,400.00	675,500.00

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	15,953,310.00	12,847,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,978,000.00	2,580,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,304,817.00	35,516,616.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,241,000.00	6,499,930.00
210604	Урсгал засвар	4,063,817.00	29,016,686.00
2107	Томилолт, зочны зардал	1,005,000.00	404,000.00
210702	Дотоод албан томилолт	1,005,000.00	404,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,490,700.00	4,077,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	419,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,585,400.00	428,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,800.00	255,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	174,500.00	182,960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000.00	772,360.00
210807	Газрын төлбөр	200,000.00	19,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,860,574.00	24,333,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,660,574.00	24,333,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,862,327.64	76,688,438.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,812,900.00	56,873,190.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,670,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,459,900.00	32,222,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,353,000.00	980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	113,049,427.64	19,815,248.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,049,427.64	19,815,248.75
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,070,062,600.00	1,029,654,347.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,062,600.00	1,029,654,347.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,087,000.00	972,781,157.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	618,294,000.00	602,042,973.60
210101	Үндсэн цалин	388,070,700.00	374,063,419.00
210102	Нэмэгдэл	153,992,700.00	167,097,120.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,128,500.00	25,813,225.00
210104	Урамшуулал	39,102,100.00	35,069,209.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,707,200.00	80,703,543.90
210201	Тэтгэврийн даатгал	58,905,100.00	56,652,362.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,200,500.00	6,202,463.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,960,400.00	4,854,510.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,240,100.00	1,171,980.40
210205	Эрүүл мэндийн даатгал	12,401,100.00	11,822,226.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,754,200.00	191,350,009.75
210301	Гэрэл, цахилгаан	22,134,800.00	20,730,649.75
210302	Түлш, халаалт	164,271,400.00	164,271,360.00
210303	Цэвэр, бохир ус	6,348,000.00	6,348,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,409,500.00	21,399,120.00
210401	Бичиг хэрэг	2,590,600.00	2,583,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,204,300.00	6,202,053.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,592,100.00	4,592,085.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,816,200.00	2,816,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,206,300.00	5,205,482.00
2105	Нормативт зардал	35,409,900.00	16,103,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	867,100.00	675,500.00
210502	Хоол, хүнс	31,961,800.00	12,847,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,581,000.00	2,580,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,366,000.00	32,365,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	6,499,930.00
210604	Урсгал засвар	25,866,000.00	25,866,000.00
2107	Томилолт, зочны зардал	404,000.00	404,000.00
210702	Дотоод албан томилолт	404,000.00	404,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,370,600.00	4,077,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	419,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	435,300.00	428,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,300.00	255,300.00

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	182,960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	772,360.00
210807	Газрын төлбөр	193,000.00	19,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,371,600.00	24,333,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,371,600.00	24,333,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,975,600.00	56,873,190.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,975,600.00	56,873,190.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,670,800.00	23,670,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,222,400.00	32,222,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,082,400.00	980,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,070,062,600.00	1,049,469,596.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,061,062,600.00	1,040,469,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,061,062,600.00	1,040,469,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,000,000.00	9,000,396.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000,000.00	9,000,396.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	48.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	17.00
620004	Гэрээт ажилтан	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/
			Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,150,686.00	3,150,686.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,150,686.00	3,150,686.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,150,686.00	3,150,686.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,150,686.00	3,150,686.00
210604	Урсгал засвар	3,150,686.00	3,150,686.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,150,686.00	3,150,686.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,150,686.00	3,150,686.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,150,686.00	3,150,686.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, бараа материалын бүртгэлийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/6 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурлан сургалт, судалгаа, үйлдвэрлэлээр зах зээлийн эрэлт хэрэгцээг хангасан мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн чиглэлээр төрөлжсөн жишиг сургууль болохыг эрхэм зорилго болгон мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн Захирлын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/05 тоот тушаалаар Байгууллагын дотоод журмыг шинэчлэн баталсан.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Дотоод хяналтын нэгжгүй бөгөөд дотоод хяналтыг хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан мэргэжилтэн ажил үүргийн хуваарийн дагуу хэрэгжүүлж, 2021 оны ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 1,070,062.6 мянга төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,050.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,038.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 1,061,062.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 9,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 9,000.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 100 хувийн биелэлттэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 3,150.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 975,931.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 8,170.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,199.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,831.7 мянган төгрөгийн ном, нийт 12,202.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,162.9 мянган

төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 11,039.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 13,766.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 91,071.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 119,275.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 63.4 мянган төгрөг, өглөг 63.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь хувь хүн, байгууллагаас авах авлага, ажиллагсадтай холбоотой өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дангүй байна. Бараа материал 161,835.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,162,507.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	63.40	63.40
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	159,662.13	161,835.42	2,173.29
Үндсэн хөрөнгө	2,298,935.82	2,162,507.43	(136,428.39)
Нийт хөрөнгө	2,458,597.95	2,324,406.25	(134,191.70)
Өр төлбөр	-	63.40	63.40
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,458,597.95	2,324,342.85	(134,255.10)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,458,597.95	2,324,406.25	(134,191.70)

Бараа материалын дансны үлдэгдэл 161,835.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,173.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,162,507.4 мянган төгрөг болж 136,428.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,324,342.8 мянган төгрөг болж 134,255.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,070,062.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 1,013,087.0 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 56,975.6 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,013,087.0 мянган төгрөгийн урсгал зардал, 56,975.6 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 1,040,469.2 мянган төгрөгийн санхүүжилт, 9,000.4 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, нийт 1,049,469.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,029,654.3 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 19,815.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,029,654.3 мянган төгрөг буюу 96.2 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Юнител ХХК-аас түрээсийн орлого 3,150.7 мянган төгрөг төвлөрч, урсгалд зардалд 3,150.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бараа материалын дансанд 28 нэр төрлийн 25,735.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй, хөрөнгө материалыг зөв ангилан бүртгээгүй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 1,183.0 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж бэлтгэснийг бараа материалын данс бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 80 нэр төрлийн 80,395.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь ТБОНӨТухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 336.8 мянган төгрөгийн хүнсний материал бүртгэлтэй байгаа нь нягтлан бодогч солигдож, бараа материалын орлого, зарлагын бүртгэлийг санхүүгийн программд эхэлж авснаа эхэлж зарлагдах арга ашиглан бүртгээгүйгээс шалгаалсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 103,215.9 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн шийдвэрлэлт, бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 107,647.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 309.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 107,338.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 309.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Ур чадварын нэмэгдэл олгох удирдлагын тушаалаар баталсан хувь хэмжээг нэмэгдүүлэн 2 албан хаагчид нийт 60.5 мянган төгрөгийн Ур чадварын нэмэгдэл цалин илүү тооцон олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12.11.2 дах заалт, журмын хавсралт №2-д заасныг үндэслэн илүү олгосон нэмэгдэл цалинг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын удирдах албан тушаалтан Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэж байх хугацаандаа өөртөө тушаал гарган Ур чадварын нэмэгдэл 248.9 мянган төгрөгийг тооцон олгосон нь: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12.11.2 дах заалт, журмын хавсралт №2-д заасныг үндэслэн өөртөө тушаал гарган олгосон нэмэгдэл цалинг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 80 нэр төрлийн 80,395.7 мянган төгрөгийн үнэ бүхий үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТБОНӨТухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 28 нэр төрлийн 25,735.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12 болон УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж байх

3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 3 нэр төрлийн 870.0 мянган төгрөгийн үнэ бүхий үлдэх өртөггүй биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12 болон УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 1 нэр төрлийн 336.8 мянган төгрөгийн үнэ бүхий Хүнсний материал бүртгэлтэй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.22 Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна” гэсэнтэй нийцэхгүй, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зарцуулахдаа ЭАЭЗ аргыг ашиглаж хэвших

5. Шилэн данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	7	107,647.7	-	-	2	309.4	-	-	5	107,338.3

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn